АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Байгаль орчны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2025/11/-НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br>Архангай аймаг<br>2025 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br><br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор П.Цэцэгдулам<br>Цахим хаяг: Tsetsegdulap@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**........3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ........5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан........5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан........6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан........8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан........10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан........11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан........13
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**........14
**5.1 Албан шаардлага**........14
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**........15

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БГАҮТХ | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж |
| БОУАӨС | Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайд |
| ЗГ | Засгийн газар |
| МУЕА | Монгол улсын ерөнхий аудитор |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нуттийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар бар,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.21 № 84

танай ____________-ны №____________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.БАЯРЦЭЦЭГ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Байгаль орчны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчид 4,618.9 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмжийг цалингийн сангаас олгосон.
- Тайланд онд 27,180.0 мянган төгрөгийн авлагатай ажилласан.

Дээрх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27 дугаар зүйлийн 27.2, 43 дугаар зүйлийн 43.3.2, Монгол Улсын засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батласан "Төрийн жинхэнэ алба хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.1, БОАЖГ-ын дарга /тухайн үед/ аж ахуй нэгж, иргэнтэй байгуулсан гэрээний 3.3.5 дахь заалтыг зөрчсөн бөгөөд тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Аудитын гол асуудал**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх нийт 3 арга хэмжээний хүрээнд орон нутгийн төсвөөс 1,813,101.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэл 92.6 хувь буюу 1,679,800.4 мянган төгрөгийг зарцуулж 134,249.6 мянган төгрөгийн төвлөрүүлсэн байна. Энэ нь төрийн албан хаагчийн үндсэн цалин, нэмэгдлийг өндрөөр тооцоолж төлөвлөсөнтэй холбоотой байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 үндсэн зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний 38 арга хэмжээг 100 хувийн хэрэгжилттэй, 3 арга хэмжээг 90 хувийн хэрэгжилттэй, 3 арга хэмжээ 70 хувийн хэрэгжилттэй, 1 арга хэмжээг үнэлэх боломжгүй нийт арга хэмжээний хэрэгжилт 96.6 хувьтай байна.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 11,127,700.00 | 33,719,310.00 |
| 33 | АВЛАГА | | 27,180,000.00 |
| 335 | Бусад авлага | | 27,180,000.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | | 27,180,000.00 |
| 34 | УРЬДЧИЛГАА | | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 11,127,700.00 | 6,539,310.00 |
| 354 | Хангамжийн материал | 11,127,700.00 | 6,539,310.00 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 508,000.00 | 182,000.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 6,970,700.00 | 6,357,310.00 |
| 3544 | Түлш, шатах тослох материал | 3,600,000.00 | |
| 3547 | Бусад хангамжийн материал | 49,000.00 | |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 161,627,255.58 | 526,248,806.94 |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | | |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 161,627,255.58 | 526,248,806.94 |
| 392 | Биет хөрөнгө | 150,587,255.58 | 508,888,806.94 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 21,122,629.40 | 21,122,629.40 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -17,305,585.40 | -17,479,087.40 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 127,193,615.00 | 505,170,611.50 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -109,790,281.98 | -134,993,801.72 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 54,299,900.00 | 58,691,370.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -26,025,566.39 | -17,842,745.00 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 21,816,864.00 | 22,659,700.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -12,608,061.47 | -13,873,778.71 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 135,224,334.00 | 134,407,334.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -43,351,591.58 | -48,973,425.13 |
| 39217 | Ном | 11,000.00 | |
| 393 | Биет бус хөрөнгө | 11,040,000.00 | 17,360,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,260,000.00 | -1,440,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 10,800,000.00 | 17,300,000.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 172,754,955.58 | 559,968,116.94 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 172,754,955.58 | 559,968,116.94 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 172,754,955.58 | 559,968,116.94 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 210,736,397.50 | 210,736,397.50 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -44,582,155.20 | 342,631,006.16 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | -44,582,155.20 | -44,582,155.20 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 387,213,161.36 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 6,600,713.28 | 6,600,713.28 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 172,754,955.58 | 559,968,116.94 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,366,592,100.00 | 2,383,327,033.50 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 37,300,000.00 | 443,864,526.50 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 37,300,000.00 | 443,864,526.50 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 36,300,000.00 | 396,979,166.50 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 1,000,000.00 | 46,885,360.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,329,292,100.00 | 1,939,462,507.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 22,230,000.00 | 126,360,807.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 52,425,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 73,830,807.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 22,230,000.00 | 105,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1,307,062,100.00 | 1,813,101,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,307,062,100.00 | 1,813,101,700.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,346,705,891.56 | 1,918,248,454.02 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,346,705,891.56 | 1,918,248,454.02 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,248,432,899.45 | 1,537,575,447.03 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 972,912,786.39 | 1,204,371,695.39 |
| 210101 | Үндсэн цалин | 573,650,311.73 | 744,197,018.92 |
| 210102 | Нэмэгдэл | 285,061,333.21 | 379,351,487.14 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 32,219,109.00 | 30,674,000.00 |
| 210104 | Урамшуулал | 81,982,032.45 | 50,149,189.33 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 123,718,409.50 | 151,226,150.62 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 84,550,501.49 | 106,805,782.10 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,877,827.22 | 12,026,251.50 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,904,661.90 | 6,120,401.92 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,944,124.54 | 2,626,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,441,294.35 | 23,647,515.10 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 10,218,041.00 | 11,172,776.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 958,435.00 | 1,065,514.00 |
| 210302 | Түлш, халаалт | 8,873,086.00 | 8,873,090.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 386,520.00 | 1,234,172.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 23,666,591.00 | 30,493,450.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,054,100.00 | 4,394,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,073,200.00 | 23,459,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,266,410.00 | 1,380,940.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 330,900.00 | 300,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,941,981.00 | 959,310.00 |
| 2105 | Нормативт зардал | 9,785,000.00 | 1,680,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 1,680,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 9,785,000.00 | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 29,020,139.00 | 23,305,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 21,824,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 29,020,139.00 | 1,480,700.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 10,045,800.00 | 4,432,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,045,800.00 | 4,432,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 10,335,791.00 | 7,220,421.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,332,400.00 | 6,576,700.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 297,675.00 | 239,625.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 173,516.00 | 288,716.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 450,000.00 | |
| 210807 | Газрын төлбөр | 49,200.00 | 49,200.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | 11,180.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 58,730,341.56 | 103,673,954.02 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,701,000.00 | 50,276,750.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 55,029,341.56 | 53,397,204.02 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 98,272,992.11 | 380,673,006.99 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 42,869,660.00 | 246,423,336.02 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 20,070,900.00 | 26,573,580.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 215,856,756.02 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 22,798,760.00 | 3,993,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 55,403,332.11 | 134,249,670.97 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 55,403,332.11 | 134,249,670.97 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 19,886,208.44 | 465,078,579.48 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 77,865,418.12 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 77,865,418.12 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | | -77,865,418.12 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 19,886,208.44 | 387,213,161.36 |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,329,292,100.00 | 1,939,462,507.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,329,292,100.00 | 1,939,462,507.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 22,230,000.00 | 126,360,807.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 52,425,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 73,830,807.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 22,230,000.00 | 105,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1,307,062,100.00 | 1,813,101,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,307,062,100.00 | 1,813,101,700.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,300,278,100.00 | 1,840,557,500.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,300,278,100.00 | 1,840,557,500.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,202,005,107.89 | 1,459,884,493.01 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 972,912,786.39 | 1,204,371,695.39 |
| 210101 | Үндсэн цалин | 573,650,311.73 | 744,197,018.92 |
| 210102 | Нэмэгдэл | 285,061,333.21 | 379,351,487.14 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 32,219,109.00 | 30,674,000.00 |
| 210104 | Урамшуулал | 81,982,032.45 | 50,149,189.33 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 123,718,409.50 | 151,226,150.62 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 84,550,501.49 | 106,805,782.10 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,877,827.22 | 12,026,251.50 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,904,661.90 | 6,120,401.92 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,944,124.54 | 2,626,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,441,294.35 | 23,647,515.10 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 10,218,041.00 | 11,172,776.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 958,435.00 | 1,065,514.00 |
| 210302 | Түлш, халаалт | 8,873,086.00 | 8,873,090.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 386,520.00 | 1,234,172.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 27,473,841.00 | 25,583,450.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,999,100.00 | 3,084,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,835,950.00 | 19,859,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,266,410.00 | 1,380,940.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 425,000.00 | 300,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,947,381.00 | 959,310.00 |
| 2105 | Нормативт зардал | 9,785,000.00 | 1,680,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 1,680,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 9,785,000.00 | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 32,015,439.00 | 21,550,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 616,000.00 | 20,069,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 31,399,439.00 | 1,480,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2107 | Томилолт, зочны зардал | 10,045,800.00 | 4,432,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,045,800.00 | 4,432,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 10,335,791.00 | 35,384,421.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,332,400.00 | 34,740,700.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 297,675.00 | 239,625.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 173,516.00 | 288,716.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 450,000.00 | |
| 210807 | Газрын төлбөр | 49,200.00 | 49,200.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | 11,180.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,500,000.00 | 4,483,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,500,000.00 | 4,483,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 98,272,992.11 | 380,673,006.99 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 42,869,660.00 | 246,423,336.02 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 20,070,900.00 | 26,573,580.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 215,856,756.02 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 22,798,760.00 | 3,993,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 55,403,332.11 | 134,249,670.97 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 55,403,332.11 | 134,249,670.97 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 29,014,000.00 | 98,905,007.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 29,014,000.00 | 98,905,007.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 29,014,000.00 | 98,905,007.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 29,014,000.00 | |
| 223001 | Бусад хөрөнгө | | 98,905,007.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -29,014,000.00 | -98,905,007.00 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 210,736,397.50 | 6,600,713.28 | -44,582,155.20 | 172,754,955.58 |
| 2 | Тайлант үеийн үр дүн | | | 387,213,161.36 | 387,213,161.36 |
| 3 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 210,736,397.50 | 6,600,713.28 | 342,631,006.16 | 559,968,116.94 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,813,101,700.00 | 1,679,800,489.03 | 133,301,210.97 | 92.65 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,813,101,700.00 | 1,679,800,489.03 | 133,301,210.97 | 92.65 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,561,260,600.00 | 1,433,377,153.01 | 127,883,446.99 | 91.81 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,313,102,400.00 | 1,204,371,695.39 | 108,730,704.61 | 91.72 |
| 210101 | Үндсэн цалин | 795,514,200.00 | 744,197,018.92 | 51,317,181.08 | 93.55 |
| 210102 | Нэмэгдэл | 406,866,700.00 | 379,351,487.14 | 27,515,212.86 | 93.24 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 48,041,500.00 | 30,674,000.00 | 17,367,500.00 | 63.85 |
| 210104 | Урамшуулал | 62,680,000.00 | 50,149,189.33 | 12,530,810.67 | 80.01 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 164,474,200.00 | 151,226,150.62 | 13,248,049.38 | 91.95 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 111,950,200.00 | 106,805,782.10 | 5,144,417.90 | 95.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,131,000.00 | 12,026,251.50 | 1,104,748.50 | 91.59 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,504,800.00 | 6,120,401.92 | 4,384,398.08 | 58.26 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,626,200.00 | 2,626,200.00 | | 100 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 26,262,000.00 | 23,647,515.10 | 2,614,484.90 | 90.04 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 12,313,200.00 | 11,172,776.00 | 1,140,424.00 | 90.74 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,820,400.00 | 1,065,514.00 | 754,886.00 | 58.53 |
| 210302 | Түлш, халаалт | 8,874,000.00 | 8,873,090.00 | 910 | 99.99 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,618,800.00 | 1,234,172.00 | 384,628.00 | 76.24 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 21,820,700.00 | 21,784,410.00 | 36,290.00 | 99.83 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,000,000.00 | 3,000,000.00 | | 100 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,200,000.00 | 16,164,600.00 | 35,400.00 | 99.78 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,360,500.00 | 1,360,500.00 | | 100 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 300,000.00 | 300,000.00 | | 100 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 960,200.00 | 959,310.00 | 890 | 99.91 |
| 2105 | Нормативт зардал | | | | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,481,000.00 | 1,480,700.00 | 300 | 99.98 |
| 210604 | Урсгал засвар | 1,481,000.00 | 1,480,700.00 | 300 | 99.98 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 4,202,600.00 | 4,132,000.00 | 70,600.00 | 98.32 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,202,600.00 | 4,132,000.00 | 70,600.00 | 98.32 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 43,866,500.00 | 39,209,421.00 | 4,657,079.00 | 89.38 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 41,850,000.00 | 38,565,700.00 | 3,284,300.00 | 92.15 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 534,800.00 | | 534,800.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 691,600.00 | 239,625.00 | 451,975.00 | 34.65 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 368,900.00 | 288,716.00 | 80,184.00 | 78.26 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 110,700.00 | 55,000.00 | 55,700.00 | 49.68 |
| 210807 | Газрын төлбөр | 156,800.00 | 49,200.00 | 107,600.00 | 31.38 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 153,700.00 | 11,180.00 | 142,520.00 | 7.27 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | | | |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 251,841,100.00 | 246,423,336.02 | 5,417,763.98 | 97.85 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 251,841,100.00 | 246,423,336.02 | 5,417,763.98 | 97.85 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 26,573,600.00 | 26,573,580.00 | 20 | 100 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 221,232,000.00 | 215,856,756.02 | 5,375,243.98 | 97.57 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,035,500.00 | 3,993,000.00 | 42,500.00 | 98.95 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,813,101,700.00 | 1,679,800,489.03 | 133,301,210.97 | 92.65 |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,813,101,700.00 | 1,679,800,489.03 | 133,301,210.97 | 92.65 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,813,101,700.00 | 1,679,800,489.03 | 133,301,210.97 | 92.65 |
| 2 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | 0.00 | |
| 5 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 54.00 | 48.00 | 6.00 | |
| 6 | Удирдах ажилтан | 1.00 | 0.00 | 1.00 | |
| 7 | Гүйцэтгэх ажилтан | 47.00 | 42.00 | 5.00 | |
| 8 | Үйлчлэх ажилтан | 6.00 | 6.00 | 0.00 | |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 126,360,807.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 126,360,807.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 125,412,347.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,799,040.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 84,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,694,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 20,440.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,680,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 1,680,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 34,819,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 31,719,000.00 |
| 210602 | Тавилга | 3,100,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 300,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 300,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,500,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,500,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 78,314,307.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 78,314,307.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 948,460.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | |
| | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 948,460.00 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 126,360,807.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 126,360,807.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 52,425,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 73,830,807.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 105,000.00 |
| | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй, харин залруулагдаагүй нийт **33,336.1** мянган төгрөгийн зөрчил[1] илэрсэнд 3 төлбөрийн акт тогтоож, зөрчил таслан зогсоож, арилгуулах 2 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 4 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 33,336.1 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн **11,785.2** мянган төгрөгөөс их, шинж чанарын хувьд материаллаг байгаа тул “**Хязгаарлалттай” дүгнэлт** өглөө.

### 5.1 Албан шаардлага

5.1.1 Аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн Б/41 дүгээр захирамжаар тус газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдон ажилласан ойн албаны даргад үндсэн цалингийн 40 хувиар тооцож холбогдох хууль журамд зааснаас 1,537.2 мянган төгрөгийн цалин хөлсийг илүү олгосон байна.

Энэ нь Монгол Улсын засгийн газрын 2019 оны 09 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ алба хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.1-т "Төрийн албаны тухай хуулийн 42.1-д заасан үндэслэлээр эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг 2-оос 6 сар хүртэл хугацаагаар түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид цалингийн зөрүүг олгоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

***Шийдвэрлэсэн нь***: Зөрчлийг давтан гаргахгүй таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

5.1.2 Өөрийн хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгдсөн албан хаагчид аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн Б/37 дугаар захирамжаар нийт 4,618.9 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмжийг цалингийн сангаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалттай нийцэхгүй байна.

***Шийдвэрлэсэн нь***: Зөрчлийг давтан гаргахгүй байх, таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

5.1.3 "Тэр бум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 7 аж ахуй нэгж, 1 иргэнтэй байгуулсан "Мод үржүүлгийн газрын тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх" гэрээний дагуу 2024, 2025 онд эргэн төлөгдөх 27,180.0 мянган төгрөгийн үнэ бүхий мод, бут сөөгний тарьц, суулгацын авлагыг барагдуулах гэрээний үүргийн биелэлтийг хангаж ажиллаагүй байна.

Энэ нь БОАЖГ-ын дарга /тухайн үед/ аж ахуй нэгж, иргэнтэй байгуулсан гэрээний 3.3.5-т "Мод үржүүлгийн газрын тоног төхөөрөмжийн нийт үнийн дүнгийн 40 хувь буюу 27,180.0 /9*3,020,000/ мянган төгрөгийн үнэ бүхий тарьц, суулгацыг "Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд үнэ төлбөргүйгээр 2024-2025 онд аймагт нийлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна

***Шийдвэрлэсэн нь***: Зөрчлийг таслан зогсоож авлагыг гэрээт хугацаанд барагдуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүллээ.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цалин хөлсийг зөрүүтэй тооцсон | 1 | 1,537.1 | | | 1 | 1,537.1 | | | | | | |
| Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн албан хаагчид тэтгэмж олгосон | 1 | 4,618.9 | | | 1 | 4,618.9 | | | | | | |
| Авлагын барагдуулах арга хэмжээ аваагүй | 1 | 27,180.0 | | | 1 | 27,180.0 | | | | | | |
| Төрийн албаны хууль зөрчиж түр томилгоо хийгдсэн | 1 | | | | 1 | | | | | | | |
| **Нийт дүн** | **4** | **33,336.1** | | | **4** | **33,336.1** | | | | | | |

5.1.4 Байгаль орчны газрын дарга буюу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог хуулийн дагуу нөхөх арга хэмжээ аваагүй, аймгийн Засаг даргын захирамжаар 3 удаа түр томилгоо хийгдсэн байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27 дугаар зүйлийн 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ", 43 дугаар зүйлийн 43.3.2-т "Дэд дарга, орлогчгүй, эсхүл эзгүй тохиолдолд байгууллагын даргын албан үүргийг чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргаар түр орлон гүйцэтгүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

***<u>Шийдвэрлэсэн нь</u>***: Зөрчлийг таслан зогсоож хуульд заасан арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.